

**90-ээд оны Зүүн Өмнө Азийн бүс нутгийн
аюулгүй байдлын асуудал**

Дэд доктор С.Дашцэвэл.

Нэг. Бүс нутгийн аюулгүй байдлын шинэ орчин.

Бүс нутгийн аюулгүй байдлын шинэ орчинг дотоод ба гадаад талаас нь авч үзвэл эдүгээ дараах байдалтай байна.

Дотоод байдал: Юуны өмнө ЗӨА-д олон жил үргэлжилсэн “Кампучийн асуудал” үндсэндээ шийдэгдэв. Энэ нь АСЕАН-ы болон Энэтхэг-Хятадын хойгийн улсуудын хооронд олон жил үргэлжилсэн үл итгэлцлийн мананг арилгав. 1992 онд хуралдсан АСЕАН-ы гадаад хэргийн сайд нарын 25-р Зөвлөлгөөнөөр Вьетнам, Лаос улсууд “ЗӨА-ийн хамтын ажиллагааны гэрээ”-нд нэгдэж гарын үсэг зурсан явдал үүнийг нотлон харуулав.

Дотоодын аюулгүй байдлын өөр нэг асуудал бол бүс нутгийн улсуудын хоорондох хил хязгаарын зарим маргаантай асуудал байв. Үүнд: Тайланд-Лаосын хооронд, Вьетнам Камбожийн хооронд, Малайз-Индонезийн хоорондох гэх мэт. Эдгээр асуудлыг харилцан ойлголцох үндсэн дээр ямар нэг мөргөлдөөнд хүргэхгүй эв зүйгээр зохицуулсаар байна. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага - АСЕАН чухал үүрэг гүйцэтгэж байна.

90-ээд оноос хойш ЗӨА-ийн улс тус бүрийн дотоод аюулгүй байдал нэлээд бэхжих боллоо. Юуны өмнө Дэлхийн коммунист хөдөлгөөний нэр хүнд унасантай уялдан засгийн газрын эсрэг коммунист бүлэглэлүүдийн хагалан бутаргах үйл ажиллагаа намдав. Үүний нэг тод жишээ бол дөч гаруй жил зэвсэгт тэмцэл хийсэн Малайзын коммунист бүлэглэл эвлэрэл зохицолд хүрэв. Мөн партизаны тэмцэл хийж байсан Филиппиний коммунист бүлэглэл, лалын бүлэглэлийн хооронд саяхан эвийн гэрээ байгуулагдав. Камбожийн эвслийн засгийн газрын эсрэг улаан Кхмерийн бүлэг хагалан бутаргах үйл ажиллагааг үргэлжлүүлж байгаа боловч тэдний эгнээ хумигдсаар, нэр хүнд нь гадаад дотоодод улам унасаар байна. Ийнхүү ЗӨА-ийн бүс нутгийн дотоод байдал үндсэндээ урд урдаас илүү тогтворжиж байгаа бөгөөд бүс нутгийн улс орнуудын хоорондын харилцаа ч улам нягтарч байна.

Хүйтэн дайны жилүүдэд бүс нутгийн аюулгүй байдалд бэрхшээл учруулж байсан үндсэн гол шалтгаанууд эдүгээ бараг үгүй болжээ. Гэвч бүс нутаг бүрмөсөн айх аюулгүй амар жимэр болсон гэж хараахан үзэж болохгүй бөгөөд шинэ нөхцөлд шинэ болгоомжлол буй болов.

Энэ нь бүс нутгийн гадаад орчинд аюулгүй байдлын хуучин тогтолцоо эвдэрсэнтэй холбоотой юм.

Гадаад байдал: 90-ээд оны эхээр хүйтэн дайны үе шувтарч АНУ, Оросын цэргийн баазууд Зүүн Өмнөд Азийн бүс нутгаас гарсан явдал энэ бүс нутагт их гүрнүүдийн “хоосон зайг” буй болгов. Энэ нь ЗӨА-ийн улсуудын сэтгэлийг зовоож тэнд буй “хоосон зайг” Хятад, Япон зэрэг хөрш зэргэлдээх том гүрнүүдийн аль нэг эзэлж, бүс нутгийн аюулгүй байдалд аюул занал учруулах вий гэсэн болгоомжлол төрүүлэв.

1992 онд Филиппиний нийслэлд хуралдсан АСЕАН-ы Гадаад хэргийн сайд нарын уулзалтаар АНУ-д хандаж бүс нутаг дахь цэргийн оролцоогоо хэвээр байлгах хүсэлтийг тавьсан боловч АНУ-ын бодлогыг өөрчилж чадсангүй.

ЗӨА-ийн байдал хурцадсан нөхцөлд бүс нутгийн улсуудын зарим цэргийн баазыг түр ашиглах боломж АНУ-ын хувьд нээлттэй хэвээр байгаа ч гэсэн улс орныхоо дотоод асуудалд илүү анхаарч Ази, Номхон далайн бүс нутагт буй ашиг сонирхлоо хамтын хүчээр хамгаалахыг илүү эрмэлзэх болов.

Оросын Холбооны Улсын хувьд Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засаг, улс төр, цэргийн нөлөөгөө бэхжүүлэх сонирхлоо орхиогүй байгаа боловч бодит боломж нь хязгаарлагдмал хэвээр байна.

Хөрш Хятад улсын хувьд ЗӨА-ийн бүс нутагт хамгийн ойр байршилтай бөгөөд эдийн засаг улс төр, цэргийн нөлөө нь давамгайлах магадлал харьцангуй их байгаа билээ. Хятадын эдийн засгийн шинэчлэл амжилттай хэрэгжиж хөгжлийн хурд нь цаашид өнөөгийн байдлаар үргэлжилвэл удахгүй эдийн засгийн төдийгүй цэргийн том гүрэн болох төлөв бий. Сүүлийн үед БНХАУ өмнөд Хятадын тэнгис дэх нутаг дэвсгэрийн маргаанд хатуу байр суурь баримталж, тэнгисийн цэргийн хүчээ бэхжүүлж байгаа нь ЗӨА-ийн улсуудын болгоомжлолыг нэмэгдүүлж байна. Ялангуяа 1992 оны 2-р сард БНХАУ-ын Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн хурлын чуулганаас “Далайн хил хязгаарын тухай хууль”-ийг шинэчлэн баталж, түүндээ өмнөд хятадын тэнгис дэх маргаантай бүх арлуудыг БНХАУ-ын нутаг дэвсгэр хэмээн тунхаглаж, “Гадаадын усан

онгоцууд Хятадын далайн хил хязгаарын хуулийг зөрчсөн тохиолдолд БНХАУ-ын тэнгисийн цэргийн хөлөг онгоц, байлдааны нисэх онгоцууд уг үйлдлийг таслан зогсоох, саатуулах, цохилт өгөх эрхтэй” /БНХАУ-ын далайн хил хязгаарын хуулийн 14-р зүйлд/ гэсэн заалт оруулсан явдал чухамдаа хятадын өмнөд хилд залгаа оршдог Вьетнам, хойд Индонез, Бруней, Малайз, Филиппин зэрэг ЗӨА-ийн олон орныг түгшээж байна.

Япон нь АСЕАН-ы гишүүн улсуудын худалдааны хамгийн том түнш бөгөөд Японтой хийж буй худалдаа АСЕАН-ы нийт худалдаа эргэлтийн 30 гаруй хувьтай тэнцэнэ. Энэ нь болгов. Энэ нь АНУ-тай хийж буй худалдаанаас давдаг. Японы хөрөнгө оруулалт энэ бүс нутагт 1951 оноос эхэлсэн бөгөөд нийт хэмжээгээрээ Америк Баруун Европын дараа орж байна. Үүнийг дагаад Японы улс төрийн нөлөө тус бүс нутагт өсөх хандлага бий. ЗӨА-ийн улсууд Дэлхийн II дайны үед Японд эзлэгдэж байсан түүхийг мартаагүй бөгөөд Японы зэвсэгт хүчин сэргэж ЗӨА-дахь хэт нөлөө нь өсөхөөс болгоомжлох сэтгэлгээ байсаар байна.

Энэтхэг бол ЗӨА-ийн хил залгаа оршдог, олон зуун жилийн уламжлалт соёл, түүхийн харилцаатай улс. Олон сая хүн амтай Энэтхэг улсын төрийн бодлого эдийн засгийн чадамж ямар байх нь ЗӨА-ийн байдалд холбоотой. Сүүлийн үед Энэтхэг улсын эдийн засаг муугүй хөгжиж гадаад бодлогоо шинэ нөхцөлд зохицуулан өөрчилж байна. Энэтхэг улсын бүс бодлого Ази, Зүүн Ази руу чиглэж, Азийн том орнуудтай харилцаа холбоогоо мэдэгдэхүйц бэхжүүлж байна. ЗӨА-ийн улсууд Энэтхэгийн нөлөө бүс нутагт хэр зэрэг өсөхийг анхааралтай ажиглан харж байна.

Ийнхүү ЗӨА-ийн бүс нутагт нөлөө бүхий том гүрнүүд /АНУ, Япон, Орос, Хятад, Энэтхэг/-ийн хандлагыг авч үзвэл Орос, АНУ-ын цэргийн нөлөө суларч, Хятад, Япон, Энэтхэгийн бодлого идэвхжих төлөв ажиглагдана. Энэ бүс нутагт хамгийн ойр, ашиг сонирхол нь хамгийн их холбогдсон нөлөө бүхий улсууд гэвэл Хятад, Япон байна. Үүний дотроос Хятад улс өмнөд далайн хилийн асуудалтай холбогдон ЗӨА хүчээ бэхжүүлж байгаа нь ЗӨА-ийн олонхи улсуудын аюулгүй байдалд шууц, нөлөөлж буй их гүрэн бөгөөд сүүлийн жилүүдэд хилийн асуудалд төдийлөн ахиц гарахгүй байгаа тул Хятадын болзошгүй хүчирхийллээс ЗӨА-ийн улсууд эмээсэн хэвээр байна. Ийм нөхцөлд ЗӨА-ийн

улсууд зэвсэгт хүчний хувьд дангаараа аюулгүй байдлаа хамгаалах боломж тун бага бөгөөд их гүрнүүдийн хүчний харьцааг тэнцвэртэй болгох бодит боломж ч өнөө үед хараахан бүрэлдээгүй байна. Учир нь цэргийн их гүрнүүдийн бодлого хүйтэн дайны үеийнх шиг бие биенээ сөрөн зогсоход биш итгэлцлийг бэхжүүлж хамтын аюулгүйн тогтолцоог бий болгоход чиглэгдэх болжээ.

2. ЗӨА-ийн улсуудын аюулгүйн бодлого

Хүйтэн дайны үед АСЕАН-ы улсуудын хувьд бүс нутгийн аюулгүй байдлыг хамгаалах хоёр үндсэн үзэл байв. **Нэгдүгээрт:** АНУ-тай цэргийн талаар холбоотой байж аюулгүй байдлаа хамгаалах үзэл. Түүнийг гол нь Тайланд, Филиппинийн засгийн газрууд дэмжиж байв. **Хоёрдугаарт:** бүс нутгийн улсууд төвийг сахиж, эвсэлд үл нэгдэх замаар аюулгүй байдлаа хамгаалах үзэл. Түүнийг Индонез, Малайзын төр засаг дэмжиж байв. Гэхдээ энэ хоёр үзэл аль аль нь эцсийн дүндээ АНУ-ын зэвсэгт хүчний үүрэг хариуцлагад найдсан үзэл байв. Хүйтэн дайны дараа ЗӨА-ийн улсуудад дараах байдал тодорхой болов. Үүнд: 1.Хэдийбээр бүс нутгийн аюулгүй байдал илүү тогтвортой амгалан болсон ч гэсэн их гүрнүүдийн хүчний харьцаанд өөрчлөлт гарч тэнд буй болсон цэргийн хоосон зайд Азийн их гүрнүүд /Хятад, Япон/-ийн нөлөө давамгайлах болзошгүй болсон.

2.АНУ-ын цэргийн нөлөө бүс нутагт хэвээр байх бодит нөхцөл үгүй болсон. 3.ЗӨА-ийн улсууд үндэсний эдийн засгаа түргэн хөгжүүлж дэлхийн эдийн засгийн өрсөлдөөнд байр сууриа бэхжүүлэх амин чухал зорилтоос үүдэн батлан хамгаалах салбарт төдийлөн их хөрөнгө зарах боломжгүй байгаа.

ЗӨА-ийн улсууд энэ нөхцөл байдлыг үзээд бүс нутгийн аюулгүй байдлыг хамтын хүчин чармайлтанд түшиглэн хэрэгжүүлэхээс өөр замгүй хэмээн үзжээ. Үүний тулд юуны өмнө бүс нутагтаа их гүрнүүдийн ашиг сонирхлыг бэхжүүлж тэнцвэржүүлэх, түүнийхээ үндсэн дээр хамтын хүчээр аюулгүй байдлаа хамгаалах механизмыг бүрдүүлэхийг эрмэлзэх боллоо.

Энэ бодлогынхоо хүрээнд **нэгдүгээрт** үндэсний батлан хамгаалах хүчин чадлаа хир хэмжээгээрээ зузаатгахын зэрэгцээ ЗӨА-ийн бүс нутгийн бүх улс орнуудын хүчин чармайлтыг

нэгтгэх, гэхдээ ямар нэг цэргийн эвслийн шинжтэй болохоос зайлсхийх, **хоёрдугаарт** бүс нутгийн аюулгүйн асуудлыг хэлэлцдэг гол индэр - АСЕАН-ы улсуудын Гадаад хэргийн сайд нарын жил тутмын уулзалтанд Ази, Номхон далайн бүс нутгийн томоохон улсуудыг оролцуулан ЗӨА-ийн бүс нутгийн аюулгүйн асуудалд анхаарлыг нь хандуулах болов.

1990-ээд оноос энэ уулзалтанд АНУ, Япон, Европын Холбоо, Австрали, Канад, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос оролцох болов. Эдгээр улсууд нь ЗӨА-ийн улсуудтай худалдаа, эдийн засгийн өргөн харилцаатай энэ бүс нутагт тэдний ашиг сонирхол үлэмж сүлжилдсэн онцлогтой юм. 1994 оноос тус уулзалтыг улам өргөн хүрээнд хийх болов. Үүнд бүс нутагт зөвхөн эдийн засгийн төдийгүй улс төрийн бодит сонирхол бүхий Орос, Хятад зэрэг том гүрнүүдийг оролцуулж эхэлжээ.

Ийнхүү ЗӨА-ийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг олон улсын томоохон чуулга уулзалт АРФ /Asian Regional Forum/-үүсч жил бүр чуулах болов. Бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг өргөн хүрээтэй олон улсын чуулга уулзалт бий болсноор нэг ёсондоо бүс нутагт аюулгүй байдлыг хамгаалах механизм бүрэлдэн тогтож эхлээд байна. Энэ нь тогтвортой аюулгүй байдлыг уг бүс нутагт өнө удаан хадгалах, бүс нутгийн хөгжил цэцэглэлтэнд аятай нөхцөл бүрдүүлэхэд чиглэж байгаа төдийгүй нийт Ази, Номхон далайн аюулгүй байдлыг бэхжүүлэх механизмыг бий болгоход чухал алхам болж байгаа юм.

АРФ аль нэг их гүрний эсрэг эвсэн хандаагүй бөгөөд бүх том гүрнүүд аюулгүй байдлын таатай орчинг буй болгохын төлөө нэгдэж буйгаараа онцлог юм. Үүгээрээ хүйтэн дайны үеийнхээс эрс ялгаатай байна.

Эдүгээ АРФ-ын үйл ажиллагаа нь гишүүн улсуудын сонирхож буй нийтлэг асуудлын талаар санал бодлоо илэн далангүй солилцож, харилцан биенээ ойлгох, танилцах шатанд явж байна. АРФ-ын гол цөм нь АСЕАН-ы улсууд бөгөөд ЗӨА-ийн бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд гол анхаарлаа хандуулах боловч уг асуудал нь Ази-Номхон далайн аюулгүй байдалтай нягт холбоотой учраас нэлээд өргөн хүрээтэй асуудал ч хэлцэх нь бий. Индонезийн судлаач Жюзюф Вананди-гийн үзэж буйгаар АРФ ирээдүйд хэд хэдэн үе шатыг туулах ажээ.¹

1-р шатанд улс орнуудын хооронд итгэлцлийг бэхжүүлэх явдал ажээ. Энэ үеийн үйл ажиллагааны гол нь бүс нутагт хурцадмал байдал буй болж улмаар мөргөлдөөнд хүрэх нөхцлийг таслан зогсоох, АРФ-ын хүрээний улс орнуудын, ялангуяа үзэл суртлын хувьд ялгаатай орнуудын итгэлцлийг бэхжүүлэх, батлан хамгаалах, зэвсэгт хүчний тухай мэдээллийг нээлттэй болгох г.м.

2-р шатанд зэвсэг хураах, хяналт тогтоох, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх зэрэг асуудалд дуу хоолойгоо идэвхтэй нэмэрлэгч бүс нутгийн байгууллага болж, зохион байгуулалтын хувьд хяналтын, мэдээллийн, техникийн г.м. төвүүд, байгуулагдан бэхжих,

3-р шатанд Ази, Номхон далайн хамтын аюулгүй байдлын тогтолцооны цөм болох бөгөөд хэрвээ дипломатын урьдчилан сэргийлэх арга хэмжээ ялагдалд хүрвэл эцсийн хэрэгсэл болж ашиглагдахуйц дээд хэмжээний хамтын байгууллага болох, алсдаа НҮБ-ын удирдлага доорхи дэлхийн хамтын аюулгүйн системийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох юм.

Энэ бол АРФ-ын хэтийн төлөвийн тухай гишүүн орны нэгэн эрдэмтэний төсөөлөл боловч бодит хэрэг болж хэрэгжих магадлалтай юм. Гэхдээ оролцогч орнуудын хүчин чармайлт, цаг хугацаанаас хамаарах зүйл гэдэг нь тодорхой.

Эдүгээ АРФ-ын үйл ажиллагаа дөнгөж эхний шатандаа яваа бөгөөд тийм ч учраас ЗӨА-д ашиг сонирхол нэгэнт буй болсон улсууд болон дэлхийн бодлогод нөлөө бүхий Ази, Номхон далайн том гүрнүүдийг одоохондоо нэгтгэх санал бодлоо солилцож байна. Харин манай мэт жижиг улсыг нэгтгэх сонирхол төдийлөн байхгүй байна.

Манай улс зүүн Өмнөд Азийн бүс нутгийн эдийн засаг, улс төрд нөлөө багатай, газарзүйн хувьд ч төдийлөн их ойр биш, АСЕАН-ы байгууллагатай албан ёсны харилцаа хараахан тогтоогоогүй байгаа, гэх мэт хүчин зүйл үүнд нөлөөлж байх шиг. Харин АРФ-ын үйл ажиллагааны цар хүрээ мэдэгдэхүйц тэлж, Ази, Номхон далайн аюулгүй асуудалд хүчтэй нөлөөлж ирэх үед буюу АРФ-ын хөгжлийн 2-р үеэс эхлэн Монгол улс АРФ-ын үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэх талтай.

Тийм учраас манай улсын хувьд АРФ-ын үйл ажиллагаанд албан ёсны байр сууриа эзлэх боломжийг нарийвчлан судлахдаа өөрийн улсын бодит ашиг сонирхлыг цаг хугацааны хүчин зүйлтэй уялдуулан цэгнэж үзэх нь зүйтэй юм.